

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны 12 дугаар сарын 28 өдөр

Дугаар 1/183, А/220

Улаанбаатар хот

Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах журам”-ыг нэгдүгээр, “Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилтны эрүүл мэндийн үзлэгийн маягт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тушаалыг мөрдөж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (З.Энхболд)-т, Эрүүл мэндийн хөгжлийн төв (Б.Нарантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (С.Төгсдэлгэр), Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга (Э.Ганхүү) нарт тус тус даалгасугай.

4.Тушаал батлагдсантай холбогдуулан “Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтнийг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, мэдээлэх журам батлах тухай” Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөрийн сайдын хамтарсан 2013 оны 159/A/89 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД

С. ЧИНЗОРИГ

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД

Х.БУЛГАНТУЯА

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр нийгмийн хамгааллын
сайдын 2023 оны 14 дугаар сарын 28-дрийн
A/483, A/220 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

ГАДААД АЖИЛТНЫГ МОНГОЛ УЛСАД ИРСНИЙ ДАРАА ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр урьдчилсан зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж, байгууллагын гадаад ажилтныг Монгол Улсад ирсний дараа эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Гадаад ажилтныг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахад Эрүүл мэндийн тухай хууль, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах

2.1. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсч байгаа гадаад иргэнийг аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсэхээс өмнө эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.

2.2. Эрүүл мэндийн байгууллага нь гадаад улсын иргэнд хүний дархлал хомсдолын вирусийн халдварт /ХДХВ/ДОХ/, тэмбүү өвчин, гепатитийн В, С вирусийн халдварт илрүүлэх шинжилгээ, уушгины сүрьеэл илрүүлэх рентген зураг, сэтгэцийн эрүүл мэндийн оношилгоо, шинжилгээ хийж, үзлэгийн нэгдсэн дүгнэлт гаргана.

2.3. ХДХВ/ДОХ-ын тохиолдлын мэдээлэл нь Хүний дархлал хомсдолын вирусийн халдварт, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай хуулиар зохицуулагдана.

2.4. Эрүүл мэндийн байгууллагаас гаргасан дүгнэлт болон Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д заасан бусад баримт бичигт үндэслэн Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэрийг гаргана.

2.5. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээгээр энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан өвчин илэрсэн гадаад иргэний эрүүл мэндийн мэдээллийг үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллага Халдварт өвчин судлалын үндэсний төвд илгээж, лабораторийн шинжилгээгээр баталгаажуулсны дараа Эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ.

2.6 30 хоногоос дээш хугацаагаар хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсч байгаа гадаад иргэн энэ журмын 2.2-т заасан эрүүл мэндийн үзлэгт хамрагдана.

2.7. ХДХВ, ДОХ, Сэтгэцийн өвчин илэрсэн тохиолдолд гадаад ажилтанд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохгүй.

2.8. Эрүүл мэндээр тэнцээгүй гадаад иргэний дүгнэлт, мэдээлэл баталгаажсаны дараа эрүүл мэндийн байгууллага ажлын 2 хоногт багтаан албаны цахим хаягаар Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдээлж, мөн албан бичгээр хүргүүлнэ.

2.9. Гадаад ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний мэдээллийг үзлэг хийсэн эрүүл мэндийн байгууллагын статистикч сар бүр Эрүүл мэндийн хөгжлийн төвд мэдээлнэ.

2.10. Гадаад ажилтны хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дуусч, сунгах тохиолдол бүрт энэ журмын 2.2 дахь хэсэгт заасан үзлэг, шинжилгээнд дахин хамрагдана.

2.11. Гадаад ажилтан 6 ба түүнээс дээш сараар хөдөлмөр эрхэлж байгаа тохиолдолд ХДХВ/ДОХ-ын халдварт илрүүлэх шинжилгээнд 6 сар тутамд хамрагдана.

2.12. Гадаад ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээллийг Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Гурав. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулахад тавигдах шаардлага

3.1. Гадаад ажилтанг хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл хүсч байгаа аж ахуйн нэгж байрладаг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа магадлан итгэмжлэгдсэн төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулна.

3.2. Гадаад иргэнийг үзлэг, шинжилгээнд хамруулахдаа урьдчилан цаг товлож, цахим бүртгэлд бүртгүүлж, халдвартын сэргийлэлт хяналт болон бусад дүрэм, журмыг баримтлана.

3.3. Шинжилгээний хариуг лабораторийн шинжилгээний бүртгэл, үйл оношийн шинжилгээийн бүртгэлд бүртгэж, энэ журмын хавсралтаар батлагдсан маягт дээр гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулна.

3.4. Халдварт илрүүлэх шинжилгээг мэдрэг, өвөрмөц чанар өндөртэй оношлуураар хийж, шинжилгээний хариу эргэлзээтэй тохиолдолд Халдварт өвчин судлалын үндэсний төвд холбогдох журмын дагуу илгээж, хариуг баталгаажуулна.

3.5. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээтэй холбоотой бичиг баримтыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу хадгална.

Дөрөв. Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр, хариуцлага

4.1. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж байгаа гадаад ажилтны эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөрийг Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан “Төлбөрийн жишиг хэмжээ, журам батлах тухай” журмыг мөрдлөг болгоно.

4.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд шаардагдах төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

4.3. Энэ журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.4. Энэ журмыг зөрчсөний улмаас бусдад хохирол учруулсан бол Иргэний хуульд заасны дагуу буруутай этгээд уг хохирлыг нөхөн төлнө.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын
 А/483, 11/200 дугаар сарын 22 дүгээр хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

**Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад ажилтны
 эрүүл мэндийн үзлэгийн маягт**

- A. Үзлэг, шинжилгээ хийсэн эрүүл мэндийн байгууллагын нэр

 B. Гадаад ажилтан ажиллуулж буй хуулийн этгээдийн нэр

 C. Овогнэр төрсөн огноо нас.... хүйс
 D. Иргэний харьяалал
 E. Паспортын дугаар
 F. Гадаад иргэний бүртгэлийн F дугаар

Шинжилгээний дүн /Шинжилгээний хуудсыг хавсаргана/

№	Үзүүлэлт	Хариу	Огноо	Эмчийн гарын үсэг
1	HIV 1/2			
2	TPHA			
3	HBsAg			
4	Anti-HCV			
5	Сүрьеэ, /ушигны рентген зураг/			
6	Сэтгэцийн эрүүл мэнд			

Дүгнэлт:

Эмчилгээ эрхэлсэн захирал /дарга/: /

Тамга гарын үсэг гарын үсгийн тайлал

Лабораторийн эмч: /

гарын үсэг гарын үсгийн тайлал